

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2012-10-18/**

Ажлын хэсгийн хуралдаан 2012 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 10 цагт Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Л.Гансүх, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат, Авилгатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Б.Бат-Отгон, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн н.Ган-Очир, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Татварын ерөнхий газрын мэргэжилтэн Д.Энхтуяа, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нягтлан бодогч х.Болор, Оюу толгой ХХК-ийн олон талт хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Монголын геологийн холбооны ерөнхийлөгч Т.Мөнхбат, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн ажилтан Л.Ганзориг, Байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг, Ажлын албаны зохицуулагч, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 18 гишүүн оролцож ирц 55 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Мэндбаяр, ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын тайлангийн маягтийг шинэчлэх тухай

Л.Гансүх: ОУИТБС-ын тайланг жил бүр гаргахад компаниуд болон төр засгийн байгууллагуудад тулгардаг хүндрэл, бэрхшээлийг багасгах зорилгоор бид тайлангийн маягтаа эргээд нэг харая гэж түрүүний хурлаар тохиролцсон. Тэр дагуу Монголын уул уурхайн үндэсний ассоциаци болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн төлөөлөл бүхий ажлын хэсэг ажиллаж, тайлангийн маягтыг шинэчлэх урьдчилсан санал бэлтгэн бидэнд танилцуулахаар ирсэн байна. Ерөнхийдөө 53 төрлийн татвар, төлбөрийг тайлагнуулдаг байсан бол үүний 19 төрлийг хасаад 34 төрлийн татвар, төлбөр буюу хуучин 3 нүүр байсныг 1 нүүр болгохоор санал оруулж байгаа юм байна. Гэхдээ танилцуулга хийгдэхээс өмнө бид нэг ойлголттой болох хэрэгтэй. Миний ойлгож байгаагаар компаниуд ТЕГ, АМГ, БОНХЯ, УУЯ, ЦЭГ, НДЕГ гэх мэт улсын болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад мэдээ тайлангаа тогтмол гаргаж өгдөг. Тэгэхээр манай ОУИТБС-ын тайлан нь тэр байгууллагуудад гаргаад өгчихсөн мэдээллийг дахин нэг маягт бөглүүлээд байхгүйгээр тэр төрийн байгууллагуудаас нь шуу татаад авах боломжтой байх талаас нь бид тайлангийн маягтаа эргэж нягтлж хэрэгтэй юм болов уу гэж бодож байна. Эсхүл заавал компани ОУИТБС-ы тайланг тусад нь гаргах ёстой юу?

Ган-очир: Би Уул уурхайн яамыг төлөөлж ирсэн. ОУИТБС тайлан гэдэг нь хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу зайлшгүй гаргаж өгдөг тэр ТЕГ-ын, АМГ-ын тайлан мэдээ нь санаачилгаараа гаргаж ил тод байдлын тайлан мэдээтэй нь таарч байна уу, үгүй гэдгийг тодруулах үйл ажиллагаа учир энэ 2 шугам зайлшгүй тусдаа байх ёстой юм болов уу гэж бодож байна. Тэгэхдээ бид тайлангийн маягтыг хялбарчлах тал дээр ярилцах ёстой байх.

Л.Гансүх: Миний хэлэх гээд байгаа санаа бол энэ ОУИТБС-ын тайланд байгаа зарим татвар, төлбөрүүдийг хасахаар өмнө нь нэг байсан дүнг салгаж тайлагнах гэж бөөн ажил болоод компанид бүр их хүндрэл учруулчих вий гэсэн болгоомжлолын үүднээс нухацтай хандах ёстой гээд байна. Нөгөөтэйгүүр тэртээ тэргүй компани балансын дүнгээсээ ТЕГ-т тэдэн төгрөг төлсөн, НДЕГ-т тэдэн төгрөг төлсөн гэж тайлан гаргаж байгаа. Нэгэнт манай олж мэдэх гээд байгаа мэдээнүүд нь улсад хүргэгдсэн байхад бид дахиад тэр мэдээг бөглүүлж авах хэрэг байна уу? Тэр мэдээллийн баазаас татаад авч болдоггүй юмуу гэж асууж байна?

Н.Алгаа: Бид их олон төрлийн татвар, төлбөрийн мэдээ тайлагнуулдаг явдлыг хөнгөвчилж цөөлөх тал дээр ажиллах гэж байна. Харин тэр хоёр урсгалаар тайлагнадаг байсныг нэг урсгал болгож болохгүй.

Н.Эрдэнэцог: Компаниуд татвар, төлбөр, хураамжаа төлөхдөө төрөл болгоноор нь өөр өөр дансанд тушаадаг учир дансны бүртгэлээрээ гараад ирнэ. Тиймээс компанид ямар ч төвөг учрахгүй.

Д.Энхтуяа: Манай хувьд бүх татварууд тус тусдаа дансанд тушаагддаг учраас ТЕГ-ын хувьд асуудал байхгүй. Харин тэр гаалийн татварууд яаж явдгийг мэдэхгүй байна. Үүнийг тодруулах хэрэгтэй.

Н.Эрдэнэцог: Компаниуд уул нь татваруудаа тус тусад нь бүртгэхэд асуудал байхгүй. Харин тэр гаалийн татварыг төлөхдөө бөөн дүнгээр нь төлчихдөг учраас гааль дээр зөрүү их үүсдэг.

Л.Гансүх: За тэгвэл өнөөдөртөө гаальтай холбоотой татвар, төлбөрүүдийг яах талаараа саналаа өгчихөөд дараа нь үүнийг гаальтай тусдаа ярья. За тэгээд эхнээс нь ярилцаад явъя.

Н.Эрдэнэцог: Автобензин, дизель түлшний онцгой албан татвар, Автобензин, дизель түлшний албан татварыг хасах санал оруулж байна. Учир нь энэ төрлийн татварыг уул уурхайн компаниуд бараг төлдөггүй. Ердөө өөрсдөө бензинээ импортлон оруулж ирдэг Эрдэнэт үйлдвэр, Петровичайна дачин тамсаг гэх мэт хоёр, гуравхан компаниуд төлдөг татвар юм. Дээр нь үнийн дүнгийн хувьд бага, материаллаг бус учир хасах санал оруулсан. (Маягтыг хавсаргав.)

Л.Гансүх: Гаалийн газраас энэ хоёр татварыг салгаж тайлагнахад хүндрэлгүй бол хасаж болох юм байна.

Н.Баярсайхан: Аудитын компанийнхан зөвхөн нэгтгэлд орсон 200 компанийн хүрээнд яриад байна. Гэтэл үйл ажиллагаа явуулж байгаа 1000 гаруй

компаниуд байдаг, үлдсэн 800 компанийн хувьд энэ татвар, төлбөр нь ямар байх вэ? Үүнийг Татварын ерөнхий газраас ч юмуу санал хэлмээр байна.

Л.Гансүх: Таны зөв. Гэхдээ эхний удаад энэ 200 компанийнхаа хүрээнд асуудлыг ярья. Үлдсэн компаниудын түвшинд ямар байх вэ гэдгийг судлах хэрэгтэй. Ер нь бол саналыг зөвхөн аудитын компаниас тавьж байгаа юм биш ээ. Уул уурхайн ассоциаци компаниудаа төлөөлөөд бас санал оруулж байгаа.

Н.Алгаа: 800 ч арай биш юм. 1000 гаруй лиценз эзэмшигч гэж байгаа. Лиценз эзэмшигч болгон компани биш юм. Ер нь бол идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 400 гаруй компани байдгаас 100 гаруй нь хайрга, элс зэрэг түгээмэл ашигт малтмал ашигладаг компаниуд гэж явдаг.

Н.Эрдэнэцог: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр, Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр гэсэн энэ хоёр төлбөрийг татварын хэсэгт оруулсан байна. Төлбөр учраас төлбөр хэсэгтээ оруулая гэсэн саналтай байна.

Ш.Цолмон: Төлбөр гэсэн нэртэй боловч энэ бол татвар учраас бид өмнө нь ярилцаж байгаад татвар гэсэн хэсэгт оруулсан юм.

Н.Алгаа: Татварын багц хуулинд татвар гэдэгт татвар, төлбөр, хураамжийг ойлгоно гэж заасан байдаг. Тиймээс татвар хэсэгт татваруудыг, төлбөр хэсэгт төлбөрүүдийг ангилж тавих нь зүйтэй.

Д.Энхтуяа: Тийм, татвар нь татвар, төлбөр, хураамжаас бүрддэг тул дээрх төлбөрийг төлбөр хэсэгт ангилж харуулж болно.

Л.Гансүх: За тэгвэл төлбөр гэдэгт нь оруулая.

Н.Ган-Очир: Энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөрийг улсын төсөвт төвлөрсөн, орон нутгийн төсөвт төвлөрсөн гэж хувааж харуулсан байна. Энэ ингэж харуулж болохгүй байх. Орон нутагт роялти төлбөрийг тушаадаггүй шүү дээ.

Б.Мэндбаяр: 70, 30-аараа хувааж авсан байдаг юм байна лээ.

Л.Гансүх: Роялтиг улсын төсөвт төвлөрсөний дараагаар орон нутагт 30 хувийг нь хуваарилж шилжүүлдэг. Энэ бол бидэнд хамаагүй зүйл юм, улсын төсвийн хуваарилалтын асуудал учраас тэр орон нутагт гэсэн хэсгийг хасах нь зүйтэй. За дараагийнх.

Н.Эрдэнэцог: Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварыг хууль нь хүчингүй болсон тул хасах санал оруулж байна.

Л.Гансүх: За тийм, хасая.

Н.Эрдэнэцог: Цөмийн энергитэй холбоотойгоор улсаас авах 4 төрлийн улсын тэмдэгтийн хураамжийг өмнө нь ийм төрлийн хураамж огт төлөгдөж байгаагүй, материаллаг бус гэдэг утгаар нь хасах санал оруулж байна.

Л.Гансүх: Энэ гэхдээ төлөгдөхгүй биш цаашид ийм төрлийн олборлолт хийгдвэл төлөгдөх дүнгүүд учраас дээр нь аудитын компаниудад механик хүндрэл учруулахгүй тул байж байх нь зүйтэй.

Н.Алгаа: Нэг санал байна. Энэ тэмдэгтийн хураамж нь нэг л удаа төлөгдөөд цаашид дахиж төлөгдөхгүй ийм хураамжууд байна. Тиймээс хасвал яасан юм бэ?

Л.Гансүх: Нэг удаа төлөгддөг хураамж ч гэсэн цаашид бид 200 биш 400, 800 компанийн тухайд асуудал ярина. Гэхдээ бас тэмдэгтийн хураамж нь үнийн дүнгийн хувьд өндөр биш тул нийт дүнгээрээ ч материаллаг бус байж болох юм. Хасч болох юм.

Б.Батболд: Санаачилгын зорилго бол нийтэд ил тод мэдээлэх. Цөмийн энергийн асуудал их чухал учраас олон нийт тэр тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн мэдээгээр нь ямар компани лиценз авсан байна гэдэг ч юмуу хэрэгтэй мэдээллээ олж авч болох учраас байх нь зүйтэй.

Н.Алгаа: Үүнийг тэмдэгтийн хураамж төлснөөр нь биш тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг хангах замаар олон нийтэд мэдээлэх ёстой.

Л.Гансүх: За тэмдэгтийн хураамж гэдэг утгаараа материаллаг бус учраас цөмийн энергитэй холбоотой төлдөг 4 төрлийн тэмдэгтийн хураамжийг хасая.

Н.Эрдэнэцог: Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлбөр учраас төлбөр хэсэгт оруулая гэсэн саналтай байна.

Л.Гансүх: За зөвшөөрөө.

Н.Эрдэнэцог: Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс, Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний үйлчилгээний хураамж гэсэн 3 төрлийн хураамжийг нэгтгэж буй дүнд нөлөөтэй бус, бага дүнтэй боловч зөрүү их үүсгэдэг, будлиулдаг учраас хасах санал оруулж байна.

Л.Гансүх: За хасая.

Н.Эрдэнэцог: Бусад хэсгийн торгуулийг бага дүнтэй, нөлөөтэй бус учраас хасах санал оруулж байна.

Л.Гансүх: За энэ дээр нэг асуулт байна. Одоо байгаль орчин бохирдуулсан бол торгох торгууль энэ хэсэгт тайлагнагдах уу?

Н.Эрдэнэцог: Тийм.

Л.Гансүх: Тэгвэл энэ байх ёстой. Одоо бид байгаль орчин бохирдуулсан бол тэрбум, тэрбумаар торгож, хатуу шаардлага тавина. Хуучин бол 800 сая төгрөгний хохирол учруулсан бол Захиргааны хуулиар бага дүнгээр торгодог байсан. Одоо бол 800 саяын хохирол учруулсан тэр хэмжээгээр нь торгох болсон тул торгууль гэдгийг хасахгүй ээ. Байх ёстой. Гэхдээ нөхөн төлбөр гэж манай

маягт дээр байхгүй байна. Миний түрүүний ярьсан бол нөхөн төлбөр учраас торгууль, нөхөн төлбөр хоёулаа байх ёстой юм байна. Тиймээс нөхөн төлбөр гэж тусад нь нэмж оруулая.

Д.Энхбат: Нэг санал байна. Нөхөн төлбөрийн доод талд нь дүйцүүлэн хамгаалахын зардал гээд оруулбал яасан юм бэ?

Ш.Цолмон: Энэ нь засаг талдаа тайлагнах боломжтой юм уу? Улсад төлдөггүй, компани өөрөө зардлаа гаргаад хийдэг зардал юм биш үү?

Л.Гансүх: Компанийн зардал учраас болохгүй юм байна.

Б.Мэндбаяр: Тайлангийн маягтын сайн дурын мэдээлэл хэсэгт байгаль хамгаалах ажилд зарцуулсан зардал гэсэн хэсэг байгаа. Тэр хэсэгт тайлагнаж болно.

Н.Эрдэнэцог: Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар нь нийт нэгтгэж буй дүнд нөлөөтэй бус, бага дүнтэй, компаниудын захирлууд өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийн татварыг компанийн нэр дээр төлдөгөөс зөрүү их үүсгэдэг, шалтгааныг тодруулах гэж цаг их алддаг учраас хасах санал оруулж байна.

Л.Гансүх: За хасая.

Н.Эрдэнэцог: Бусад гэсэн хэсэг нь тодорхойгүй байдаг тул компаниуд Хүн амын орлогын албан татварыг ч юм уу тайлагнасан байдаг учраас үүнийг хасах саналтай байна.

Л.Гансүх: Тийм байна. Ойлгомжгүй энэ бусад гэсэн хэсгийг хасая.

Б.Батболд:

Н.Эрдэнэцог: Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр нь уул уурхай компаниуд энэ төрлийн төлбөрийг нийтлэг төлдөггүй, материаллаг бус, Засгийн газрын тайланд энэ дүн тайлагнагддаггүй тул хасах саналтай байна.

Л.Гансүх: За хасая.

Н.Эрдэнэцог: Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглах зөвшөөрлийн хураамж. Энэ төрлийн төлбөр практик дээр төлөгддөггүй тул хасах саналтай байна.

Л.Гансүх: За хасая.

Н.Эрдэнэцог: Нутгийн захиргааны байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсийг бага дүнтэй, материаллаг бус тул хасах саналтай байна.

Л.Гансүх: Түрүүнд ярьсанчлан тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс гэдэг утгаараа хасая.

Н.Эрдэнэцог: Орон нутагт төлсөн торгуулийг хасах санал оруулсан.

Л.Гансүх: Энэ бол байх ёстой. Түрүүнд ярьсанчлан нөхөн төлбөр гэж нэмж оруулая.

Н.Эрдэнэцог: Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн гэдэгт компаниуд дээд тал нь 100,000 төгрөг төлсөн байх тул бага дүнтэй гэдэг утгаар нь хасах саналтай байна.

Л.Гансүх: Энэ байх нь зүйтэй байх.

Б.Мэндбаяр: Ашиглалтын компаниуд яаманд, хайгуулын компаниуд орон нутагт мөнгөө төлдөг юм байна лээ. Тиймээс яаманд төлсөн, орон нутагт төлсөн гээд 2 хувааж харуулбал яасан юм бэ? Тэгэхгүй бол энд их зөрүү үүсдэг.

Л.Гансүх: Энэ чинь буцаагаад авдаг биз дээ?

Б.Мэндбаяр: Буцаагаад авдаг нь их ховор юм байна лээ.

Н.Алгаа: Яаманд төвлөрсөн нь байгаад байдаг, орон нутагт төлсөн тэр барьцаа нь үрэгдээд алга болдог ийм л төлбөр юм байна л дээ.

Л.Гансүх: За тэгвэл хасахгүйгээр орон нутаг гэсэн бүлгийн бусад гэсэн хэсэгт шилжүүлэе.

Н.Эрдэнэцог: Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг гэсэн бүлгийн бусад байгууллагад гэдэг хэсгийг хасах саналтай байна. Учир нь компаниуд аймаг, суманд гэж тайлагначихаад орон нутгийн цэцэрлэг, сургуульд өгсөн хандиваа энэ бусад гэсэн хэсэгт салгаад ингээд зөрүү үүсгээд байдаг.

Л.Гансүх: Маш зөв. Суманд байдаг байгууллагад өгсөн бол суманд гэж, аймагт байдаг байгууллагад өгсөн бол аймагт өгсөн гэж тайлагнах хэрэгтэй. Гэхдээ байгууллагынхаа нэрийг бичиж тодруулахгүй бол сумын дарга өрөнд орох юм байна. За тиймээс тэр бусад байгууллага гэдгийг хасая. За тэгээд шинэ маягтаа харая. (Шинэчилсэн маягтыг хавсаргав.)

Д.Энхтуяа: Агаарын бохирдлын төлбөрийг авто тээвэр эзэмшигч, нүүрс олборлож буй компаниуд, эрчим хүчний компаниуд төлдөг байгаа. Тиймээс энэ агаарын бохирдлын төлбөр гэдгийг хаалтанд нүүрс олборлолттой холбоотойгоор гэж тайлбар бичих хэрэгтэй.

Л.Гансүх: За зөв. Хаалтанд “нүүрс олборлодог компаниуд” гэж тайлбар бичих. За дээр нь тэр Гаалийн үйлчилгээний хураамжийг 1.3-т оруулах.

Н.Эрдэнэцог: Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр гэдгийг 1.4 хэсэгт нэмж оруулах саналтай байна.

Л.Гансүх: За тийм. Тэгэхээр 1.4 Засгийн газрын бусад ба урьдчилгаа төлбөр хэсэгт 1/ Бүтээгдэхүүний хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого, 2/ Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт

ногдох орлого, 3/ Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөрүүд гэдэг 3 төрлийн орлогыг тайлагнуулая.

Тэгээд 1.6 хэсэгт Торгууль, нөхөн төлбөр гэж оруулая.

2.2.5 дээр байгаа Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр гэдгийг хуулийн хэллэгээр нь засаарай.

Н.Баярсайхан: Надад нэг санал байна. Саяны энэ хасах, засах, нэмэх гэсэн саналууд нь аудит, уул уурхайн ассоциаци, засгийн газрын байгууллагуудын санал гэж ойлгож байна. Иргэний нийгмийн зүгээс материалаа өчигдөр л авсан, эвсэлээрээ нэгдэж яриагүй учраас эцсийн саналаа хэлэх боломжгүй байна. Дээр нь энэ аудитын компанийн гаргаж байгаа санал, үндэслэлүүд нь ОУИТБС-ын Олон улсын дүрмийг зөрчсөн, үндэслэл муутай харагдаж байгаа тул бид маягт шинэчлэх асуудлыг нухацтай авч үзмээр байна. Орон нутгийн иргэдтэйгээ уулзаж, тэдний саналыг авмаар байна. Олон улсын түвшинд судалгаа хиймээр байна. Тэгж байж саналаа өгмөөр байна.

Л.Гансүх: Нэгдүгээрт, аудитын байгууллага дангаараа тайлангийн маягтад өөрчлөлт оруулая гэж санал оруулж байна гэж ойлгож болохгүй. Бид өмнөх хурлаараа 6 жил тайлан гаргалаа, өмнөхөөсөө сургамж авахгүй байна, алдаа дутагдал байсаар байна, аудитын байгууллагаас өгч буй зөвлөмжүүд давтагдсан хэвээр байгаад байна, компаниудын хандах хандлага сөрөг хэвээр байна, үүнийг бид яах вэ? яаж ажлаа сайжруулах вэ? гээд л асуудлуудыг хөндөж байсан. Тэр дагуу бид хамгийн түрүүнд эхлээд компаниудын сөрөг хандлагыг бууруулах тал дээр ажиллая, тайлан гаргаж өгөхөд тулгардаг хүндрэлүүдийг багасгая гэж тохиролцсон. Би сайн санаж байна. Тэгээд Уул уурхайн ассоциаци нь компаниудаа төлөөлөөд, аудитын байгууллага хамтраад тэр компаниудын гомдол гаргаад байгаа маягтыг хялбар, дөхөм болгох чиглэлээр ажиллаад ажлын хэсэгт танилцуулах, дараа нь засгийн зүгээс үүнтэй танилцаад зөвшилцөх, улмаар иргэний нийгэм бас саналаа хэлэх гэсэн байдлаар ажиллая гэж тохиролцсон. Хоёрдугаарт, та нар өнөөдрийг болтол энэ маягт дээрээ илүү сайн ажилласан байх ёстой байсан. Бид 11 дүгээр сарын 15 гэхэд Үндэсний зөвлөлийг хуралдуулж, тайлангаа танилцуулахдаа энэ маягтын асуудлаа давхар танилцуулах шаардлагатай байна. Хугацаа бага байгаа тул та бүхэнд тодорхой хугацаа товлож өгье. 11 дүгээр сарын 1 гэхэд иргэний нийгмийн зүгээс саналаа эцэслэж оруулж ирээрэй. Одоо харин гишүүдээс энэ маягттай холбоотойгоор өөр хэлэх санал байна уу?

Б.Осоргарав: Бидний зүгээс болсон гэж үзэж байна.

Ш.Цолмон: Ажлын албаны зүгээс санал хэлэхэд ер нь энэ тайлангийн маягтыг өөрчлөх талаар дан ганц манай оронд биш санаачилгын гишүүн 30 гаруй орнуудад бас яригдаж байна. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас санал аваад явж байна. Санаачилгын гишүүн дэлхийн олон орнуудад маягтаа аль болох либералчилъя, аль болох хөнгөвчилъе, гэхдээ үндсэн агуулгаасаа хазаахгүй байх гээд тал талд л ажил өрнөж байна. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас юу гэж зөвлөж байна вэ гэхлээр хасаж болно, нэмж ч болно үүнд асуудал байхгүй. Гол нь үндэслэлээ сайн гаргаж ирээрэй гэж байсан. Миний хувьд бидний саяны гаргасан өөрчлөлтүүд болмоор санагдаж байна. Гэхдээ энэ

өөрчилсөн маягтаараа 2012 оны тайланг хүлээн авахдаа туршилтын журмаар явуулбал яасан юм бэ? Учир нь маягтаа Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар батлах ёстой. Ингэж батлахаасаа өмнө туршилтын хугацаанд тайлангаа авч үзээд, засч сайжруулах зүйл байвал нэг мөр болгосны дараагаар батлуулах хэрэгтэй гэж бодож байна.

Л.Гансүх: За тэгэхээр анхны байдлаар компани, Засгийн газар, аудитын байгууллагууд тайлангийн маягтын өөрчлөлт дээр зөвшилцлөө гэж ойлгож байна. Одоо саяны гарсан саналуудыг тусгаад иргэний зөвлөлд хүлээлгэн өгье. Иргэний зөвлөл саналаа 11 дүгээр сарын 1-ны дотор өгөөрэй. Эргээд ажлын хэсэг 11 дүгээр сарын 2 юмуу 3-ны өдөр хуралдая. Хоёрдугаарт, энэ хурлаас өмнө Улаанбаатар аудит корпораци ХХК нэгтгэлийн тайланг эцэслэж танилцуулаарай. Түүнчлэн аймаг, аймгаар салгасан хавсралтаа 11 дүгээр сарын 15 гэхэд бэлэн болгоорой. Эцэст нь ганц зүйл нэмж хэлэхэд бид ажлын хэсгийн хурлаараа асуудлыг нээлттэй, ил тодоор хэлэлцэж, 3 тал бие биенээ шүүмжилж болно. Гэхдээ энэ хаалгаар гараад гадна талд бид нэгдсэн байр суурьтай, нэг хүн шиг явах ёстой шүү гэдгийг хатуу анхааруулъя. За ингээд өнөөдрийн хурлаа өндөрлөө. Та бүхэнд баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Гишүүдээс гарсан саналуудыг тусган маягтаа шинэчлэж ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайханд хүлээлгэж өгөхийг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав нарт даалгав.

2. Иргэний нийгмийн төлөөлөл "ТАН" эвсэл, байгаль хамгаалал иргэний зөвлөл маягт шинэчлэхтэй холбоотой саналаа 2012 оны 11 дүгээр сарын 1-ний дотор Ажлын албанд ирүүлэхээр тогтов.

3. Маягт шинэчлэхтэй холбогдуулан Гаалийн ерөнхий газартай уулзалт хийж, санал авч танилцуулахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

3. 2012 оны 11 дүгээр сарын 2-ны дотор Монгол Улсын ОУИТБС-ын зургадугаар нэгтгэлийн тайланг эцэслэн боловсруулж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэхийг Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргаравт зөвлөв.

Ажлын хэсгийн хурал 12 цагт 10 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч



Л.Гансүх

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны харилцааны мэргэжилтэн



Б.Дэлгэрмаа